



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭ

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалтын газар,
Үнэлгээ, мониторингийн газар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭ

Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
болон завсарлагааны хугацаагаар
/2025.03.15-2025.09.15/

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ.ТҮР ХОРОО

ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1.УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

2.1.1.Үйл ажиллагаа үргэлжилж буй ажлын хэсийн товч мэдээлэл

2.1.2.Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсийн товч мэдээлэл

2.2.БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

2.2.1.Үйл ажиллагаа үргэлжилж буй ажлын хэсийн товч мэдээлэл

2.2.2.Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсийн товч мэдээлэл

ГУРАВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

3.1.АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

3.2.АСУУЛТЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

ДӨРӨВ.ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

4.1.ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

4.2.БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР СОНССОН МЭДЭЭЛЭЛ

ТАВ.ДҮН ШИНЖИЛГЭЭ

5.1.УЛСЫН ИХ ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

5.2.ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

5.3.БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ЗУРГАА.ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

6.1.ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ

6.2.ТӨСВИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭХ ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТ



Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор тодорхой асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулагдан ажилласан.

Хүснэгт 1. Монгол Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо

Д/д	Хянан шалгах түр хороо байгуулсан тогтоол	Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн
1.	УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ 2025.07.02 №62	Хянан шалгах түр хорооны дарга: О.Батнайрамдал Гишүүд: М.Бадамсүрэн, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Э.Болормаа, Ш.Бямбасүрэн, П.Ганзориг, Б.Жаргалан, С.Зулпхар, Д.Пүрэвдаваа, Ө.Шижири УИХТГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажлын алба: Ажлын албаны дарга: ХШГ-ын дарга Ч.Онончимэг Нарийн бичгийн дарга: ХШГ-ын референт Д.Гэрэлт-Од, Ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Гишүүд: ЭЗБХ-ны ажлын албаны Ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн Зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Амармөрөн, ХШГ-ын референт Д.Мөнхтуяа

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйл.



1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулагдсан “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаа:


- Хянан шалгах түр хорооны 2025.08.20-ны өдрийн хуралдаанаар Хянан шалгах түр хорооны даргыг сонгосон.
- МУИХ-ын ЕНБД-ын 2025.08.11-ний өдрийн 598 дугаар захирамжаар Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх ажлын албыг байгуулсан.
- Хянан шалгах түр хорооны 2025.08.20 -ны өдрийн хуралдаанаар хянан шалгагч, шинжээчийн ажлын даалгавар, ажлын удирдамжийг хэлэлцэн баталж, 3 хянан шалгагч, 7 шинжээчийг томилсон.
- Хянан шалгах түр хорооноос 2025.08.26-ны өдөр 26 байгууллагад нотлох баримт ирүүлэх талаар албан бичгийг хүргүүлж, 2025.09.03-ны өдөр Хянан шалгагч, шинжээч нар “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-д ажиллав.
- Хянан шалгах түр хорооны 2025.09.01, 2025.09.10-ны өдрийн хуралд “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-аас “Оюутолгой төсөл, үйл ажиллагаа” сэдвээр танилцуулга мэдээлэл хийсэн.
- Хянан шалгах түр хорооны 2025.10.01-ний өдрийн хуралдаанаар “Эрдэнэс Монгол” ХХК болон “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн танилцуулга мэдээлэл болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67, 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн явцын мэдээллийг сонсов. Мөн Хянан шалгагч, шинжээч томилох тухай, Ажлын даалгавар батлах тухай, Нотлох баримт цуглуулах тухай, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслүүдийг хэлэлцэж баталсан.

2025 оны 10 дугаар сарын байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий нийт 41 ажлын хэсэг байгуулагсан (*давхардсан тоогоор Улсын Их Хурлын 445 гишүүн ажилласан*) байна.

- Үүнээс:
- Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 20;
 - Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 21 ажлын хэсэг байна.

График 1.Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

- 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (28)
- 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (12)
- 2025 оны хаврын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан (1)



Хүснэгт 2. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /*шийдвэрийн төрлөөр*/

Хугацаа	Улсын Их Хурлын даргын захирамж	Байнгын хорооны тогтоол	Дэд хорооны тогтоол
2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	17	11	-
2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	3	10	-
Үүнээс: үйл ажиллагаа дуусгавар болсон	6	11	-
Нийт - 41	20	21	-

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 20 ажлын хэсгээс 11 ажлын хэсэг үргэлжлэн ажиллаж, 6 ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон. Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 21 ажлын хэсгээс 10 ажлын хэсэг үргэлжлэн ажиллаж, 11 ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.



1.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Д/д **Ажлын хэсэг байгуулсан захирамж** **Ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

1.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.08.19 №42 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, 4.4-т заасан зорилт, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, холбогдох арга хэмжээний санал болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: М.Мандхай Гишүүд: Р.Батболд, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, П.Батчимэг, М.Ганхүлэг, Б.Заяабал, Ц.Идэрбат, С.Лүндэг, З.Мэндсайхан, Л.Соронзонболд, Р.Сэддорж, А.Ундраа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин
2.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.08.27 №59 Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2024.04.19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 31 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний санал боловсруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярбаатар Гишүүд: Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, П.Ганзориг, М.Ганхүлэг, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара
3.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №73 Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль, тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Улсын Их Хурлын даргын захирамж 2025.07.07 №311 Ажлын хэсгийн ахлагчаар томилох тухай	Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярбаатар Гишүүд: Ж.Алдаржавхлан, Ж.Баярмаа, Э.Болормаа, Г.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Б.Жаргалан, С.Замира, С.Зулпхар, Ц.Мөнхбат, Н.Наранбаатар, П.Сайнзориг, Б.Хэрлэн,
4.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №75 Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, цэгцлэх талаар санал, дүгнэлт гарган холбогдох бусад хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Бат-Эрдэнэ Гишүүд: Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, О.Батнайрамдал, Б.Бат-Эрдэнэ, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Ж.Золжаргал, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаясгалан, М.Нарантуяа-Нара, Г.Очирбат, М.Сарнай, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин
5.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №77 Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Д.Батлут Гишүүд: Ж.Алдаржавхлан, Н.Алтаншагай, Ж.Батжаргал, Х.Баттулга, П.Ганзориг, Г.Дамдинням, Ц.Идэрбат, Г.Лувсанжамц, С.Лүндэг, Н.Наранбаатар, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг
6.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №78 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах, шаардлагатай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: С.Лүндэг Гишүүд: М.Бадамсүрэн, Ж.Батжаргал, Н.Батсүмбэрэл, Б.Бейсен, Б.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, С.Замира, Н.Наранбаатар, Б.Пүрэвдорж, Д.Рэгдэл, Б.Түвшин, Дам.Цогтбаатар, Б.Уянга
7.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №79 Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Б.Уянга Гишүүд: Э.Болормаа, М.Ганхүлэг, Ж.Золжаргал, П.Мөнхтулга, Л.Мөнхбаясгалан, Д.Рэгдэл

ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

8.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №81 Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: М.Ганхүлэг
		Гишүүд: Н.Алтаншагай, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Э.Болормаа, Ш.Бямбасүрэн, Г.Лувсанжамц, М.Сарнай, Ч.Ундрэм, С.Цэнгүүн, Ө.Шижир
9.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №82 Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Д.Батлут
		Гишүүд: Н.Алтанхуяг, М.Бадамсүрэн, Ж.Батжаргал, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, С.Лүндэг,
10.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №83 Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт гаргаж, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Х.Ганхуяг
		Гишүүд: Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Б.Заяабал, У.Отгонбаяр, Г.Очирбат, Р.Сэддорж, Г.Хосбаяр,
11.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №97 Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, нийгмийн халамжийн тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Б.Жаргалан
		Гишүүд: Н.Алтаншагай, Р.Батболд Ж.Баясгалан, Б.Бейсен, Д.Ганмаа, М.Ганхүлэг, С.Зулпхар, П.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, Б.Түвшин, М.Сарнай, Л.Энхнасан
12.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №103 Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Г.Тэмүүлэн
		Гишүүд: А.Ариунзаяа, Р.Батболд, П.Батчимэг, Э.Болормаа, Б.Жаргалан, С.Зулпхар, Ч.Лодойсамбуу, Б.Мөнхсоёл, Ц.Мөнхтуяа, Н.Наранбаатар, Н.Номтойбаяр, Б.Пунсалмаа, Б.Уянга, Р.Сэддорж, Б.Хэрлэн, Л.Энхнасан, Д.Энхтүвшин, С.Эрдэнэбат
13.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №110 Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, электрон тамхи, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судлан, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: О.Номинчимэг
		Гишүүд: Д.Батбаяр, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Мөнхсоёл, М.Сарнай
14.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №111 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтүвшин
		Гишүүд: Н.Алтанхуяг, Ч.Анар, Т.Аубакир, Д.Батбаяр, Б.Баярбаатар, С.Ганбаатар, Б.Заяабал, Ө.Шижир
15.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №113 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: У.Отгонбаяр
		Гишүүд: М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Х.Болормаа, Э.Болормаа, Н.Номтойбаяр
16.	Улсын Их Хурлын даргын захирамж 2024.09.05 №115 Иргэний хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: О.Номинчимэг
		Гишүүд: Х.Баасанжаргал, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Дам.Цогтбаатар, Б.Энхбаяр, С.Эрдэнэболд
17.	Улсын Их Хурлын даргын захирамж 2025.04.23 №192 Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал, дүгнэлт боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Х.Булгантуяа
		Гишүүд: Т.Аубакир, Р.Батболд, О.Батнайрамдал, Ж.Баярмаа, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Ц.Идэрбат, М.Мандхай, Б.Мөнхсоёл, Ц.Мөнхтуяа, У.Отгонбаяр, Г.Очирбат, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Г.Тэмүүлэн, Ч.Ундрэм, Б.Уянга, Б.Хэрлэн, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд

Улсын Их Хурлын даргын захирамж 2025.05.28 №243

18. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 31 дүгээр тогтоолын хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярбаатар

Гишүүд:

Б.Батбаатар, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, З.Мэндсайхан, Г.Очирбат М.Сарнай, Г.Тэмүүлэн

Улсын Их Хурлын даргын захирамж 2024.12.02 №292

19. Татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцаж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Ганхуяг

Гишүүд:

Т.Аубакир, Р.Батболд, Ж.Баясгалан, П.Ганзориг, Б.Заяабал, Г.Лувсанжамц, О.Номинчимэг, Б.Пунсалмаа, Д.Энхтүвшин

Улсын Их Хурлын даргын захирамж 2025.07.30 №321

20. Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 41, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 46, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолуудын хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:

М.Ганхүлэг

Гишүүд:

Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Г.Лувсанжамц, М.Сарнай, С.Эрдэнэболд

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд ажилласан ажлын хэсгийн мэдээлэл.

2.1.1. Үйл ажиллагаа нь үргэлжилж буй ажлын хэсгийн товч мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйл

1. Улсын Их Хурлын даргын 2024 оны 42 дугаар захирамжаар байгуулагдсан “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, 4.4-т заасан зорилт, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, холбогдох арга хэмжээний санал болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.03.19-ний өдрийн хуралдаанаар Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл, Хүнсний тухай хуулийн төсөл, Татвар, Нийгмийн даатгалын тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцсэн.
- Ажлын хэсэг, БОХХААБХ-ны гишүүдийн хамт 2025.03.20-21-ний өдрүүдэд Дархан-Уул аймгийн ЗДТГ, ХХАА-ын газрын үйл ажиллагаатай танилцсан.
- Ажлын хэсгийн 2025.04.04, 2025.04.07, 2025.04.08-ны өдрийн хуралдаанд ажлын хэсгийн дэмжих бүрэлдэхүүнээс хүнсний аюулгүй байдлын эрх зүйн орчныг шинэчлэхтэй холбоотой асуудал, “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний явц, Шинэ хоршоо хөдөлгөөний хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар танилцуулсан.
- Ажлын хэсгээс 2025.04.23-ны өдөр зохион байгуулсан хэлэлцүүлэгт Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэхтэй холбогдуулан боловсруулсан Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн ахлагч танилцуулга хийж, хэлэлцүүлэгт оролцсон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч болон холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөлтэй санал солилцсон.



ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ



- УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Хүнсний тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг 2025.05.05-ны өдөр зохион байгуулсан.
- Ажлын хэсэг 2025.05.07, 2025.05.08-ны өдөр Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.
- Ажлын хэсгийн “Хүнсний хувьсгал” дэд хэсгийн 2025.05.13, 2025.06.12-ны өдөр хуралдаанаар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж, хэлэлцүүлсэн.
- Ажлын хэсгийн 2025.06.04, 2025.06.12-ны өдрийн хуралдаанд Хөдөө аж ахуйн тухай анхдагч хуулийн төсөл болон Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн танилцуулга, үзэл баримтлалыг хэлэлцсэн.
- Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025.06.19-ний өдөр УИХ-ын гишүүн М.Мандхай нарын гишүүдээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг нарын гишүүдээс 2025.07.04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.



2. Улсын Их Хурлын даргын 2024 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан "Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль, тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.04.02-ны өдрийн хуралдаанаар ЗГХЭГ-аас хийсэн “Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”, ТАЗ-ийн “Төрийн албан хаагчдын сэтгэл ханамж, хандлага” судалгааны тайланг сонссон.
- ЗГХЭГ-аас KOICA-тай хамтран 2025.04.04-ний өдөр зохион байгуулсан "Төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь төсөл"-ийн хүрээнд зөвлөх үйлчилгээний тайланг танилцуулах арга хэмжээнд ажлын хэсгийн гишүүд оролцсон.
- Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, ёс зүй, сахилга хариуцлагыг чанаржуулах “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” бүсчилсэн зөвлөгөөн 2025.04.14-15-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан. Тус зөвлөгөөнд ажлын хэсгийн гишүүд оролцож, ажлын хэсгийн гишүүн Б.Баярбаатар “Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал” сэдвээр илтгэл тавьсан.



3. Улсын Их Хурлын даргын 2024 оны 75 дугаар захирамжаар байгуулагдсан "Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, цэгцлэх талаар санал, дүгнэлт гарган холбогдох бусад хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.04.08-ны өдрийн хуралдаанаар “Улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгаа”-ны талаарх ХЗДХЯ-ны мэдээллийг сонссон. ЗГХЭГ-аас захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл танилцуулсан.





4. Улсын Их Хурлын даргын 2024 оны 77 дугаар захирамжаар байгуулагдсан "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.05.06-ны өдрийн хуралдаанаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн онцлог зохицуулалт, анхаарах асуудлын талаар болон хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын явцын талаар ЗГХЭГ, 20 мин хот Үндэсний хорооны мэдээллийг сонссон.
- ТББХ-ны 2025.05.13-ны өдрийн хуралдаанд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Батлут танилцуулсан.



5. Улсын Их Хурлын даргын 2024 оны 78 дугаар захирамжаар байгуулагдсан "Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах, шаардлагатай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.03.25-ны өдрийн хуралдаанд "Байгаль орчны хуулиудын бодлогын уялдаа холбоог сайжруулах үнэлгээний танилцуулга ба цаашид хийх алхамууд-IC-SF" сэдвээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас мэдээлэл хийсэн.
- Ажлын хэсгийн 2025.04.01-ний өдрийн хуралдаанаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгаль орчныг хамгаалах багц хуулийн төслүүдийн танилцуулга, мэдээллийг сонссон.



6. Улсын Их Хурлын даргын 2024 оны 110 дугаар захирамжаар байгуулагдсан "Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, электрон тамхи, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судлан, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.03.20-ны өдрийн хуралдаанд ДЭМБ-аас Женев хотноо зохион байгуулагдсан сургалт зөвлөгөөнд оролцсон. Ажлын хэсгээс Тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан болон Монгол Улс дахь тамхины онцгой албан татварын бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох тухай ДЭМБ-ын зөвлөмжийг танилцуулсан.
- Ажлын хэсгээс 2025.05.05-ны өдөр ЭМЯ-тай хамтран эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийн хүрээнд Тамхины хяналтын тухай хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Ажлын хэсгийн гишүүд 2025.05.14-ний өдөр ДЭМБ-ын төлөөлөгчидтэй уулзсан бөгөөд судлаач Чан Суанхао Монгол Улс дахь Электрон тамхины зах зээл, маркетингийн судалгааны үр дүнгийн талаар танилцуулга хийж, санал солилцсон.
- Ажлын хэсгийн ахлагч 2025.05.16-ны өдрийн УИХ-03/6286 дугаар албан бичгээр "Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөлд санал авахаар Засгийн газарт хүргүүлсэн.
- 2025.09.03-ны өдөр ажлын хэсгээс ЭМЯ-тай хамтран Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт эрүүл мэндийн салбарын эмч,





7. Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан "Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.04.23-ны өдрийн хуралдаанаар бусад ажлын хэсгүүдтэй хамтарч ажиллах талаар болон Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг дагаж өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийн талаар хэлэлцсэн.
- Ажлын хэсэг 2025.04.25-ны өдөр ХҮҮХ, ЗГХХГын төлөөллүүдтэй уулзаж төрийн хяналт шалгалтын тогтолцооны шинэчлэлийг цаашид хэрхэн төгөлдөршүүлэх талаар хамтран ажиллах асуудлаар санал солилцсон. "Төрийн хяналт шалгалтын өнөөгийн эрх зүйн орчин ба шинэчлэлийн үзэл баримтлал" сэдвээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, "Салбарын хяналт, шалгалтын хууль, эрх зүйн орчин" сэдвээр Хяналт, үнэлгээний үндэсний хорооны ажлын албаны дарга Н.Лхагвадорж нар танилцуулга хийсэн.



8. Улсын Их Хурлын даргын 2024 оны 115 дугаар захирамжаар байгуулагдсан "Иргэний хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Иргэний хууль нь Монгол Улсын иргэн бүрт хамаатай өргөн цар хүрээтэй харилцааг зохицуулдаг 552 зүйлтэй тул хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг судлан, санал, дүгнэлт боловсруулахаар Иргэний эрх зүйгээр мэргэшсэн 42 эрдэмтэн, судлаач, их сургуулийн профессорууд, холбогдох төрийн байгууллагын албан хаагчидтай хамтран ажиллаж байна. Ажлын хэсэг хамтарсан багийг дараах чиглэлээр зохион байгуулсан. Үүнд:
 - Иргэний эрх зүйн ерөнхий ангийн талаар үнэлгээ хийх I баг-7 гишүүнтэй;
 - Эдийн ба эдийн бус баялагийн эрх зүйн асуудлаар үнэлгээ хийх II баг-13 гишүүнтэй;
 - Үүргийн ба гэрээний эрх зүйн асуудлаар үнэлгээ хийх III баг-13 гишүүнтэй;
 - Өв залгамжлал, олон улсын иргэний эрх зүйн асуудлаар үнэлгээ хийх IV баг-7 гишүүнтэй;
 - Үндэслэлгүйгээр хөрөнгөжих, гэм хор учруулснаас үүсэх үүрэг гэсэн асуудлаар үнэлгээ хийх V баг-4 гишүүнтэй.
- Ажлын хэсэг 2025.04.14-ний өдөр "Иргэний хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлын дүн шинжилгээ, үр дагаврын үнэлгээ" сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэсэн V багийн хүрээнд уулзалт, хэлэлцүүлэг хийсэн.
- Ажлын хэсгийн 2025.04.18-ны өдрийн хуралдаанаар II, III баг ажлын явцын талаарх мэдээллийг сонсов. Багийн гишүүдээс ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хэлэлцсэнтэй холбогдуулан хэсгүүд тайлангаа нэгтгэн ажлын хэсэгт танилцуулахаар тогтсон.
- Ажлын хэсэг 2025.06.16-ны өдөр таван баг тус бүрээс "Иргэний хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дагаврын үнэлгээ" судалгааны тайлан (575 хуудас)-г хүлээж авсан. Ажлын хэсгийн гишүүд тайлантай танилцаж байна.





- Тайланг дуусгавар болсонтой холбогдуулан ажлын хэсэг 2025.06.10-ны өдөр Японы ОУ-ын хамтын ажиллагааны агентлагийн Хууль, эрх зүйн хөгжлийн зөвлөх Таро Моринога, Хууль зүйн яамны судалгааны хүрээлэнгийн ажилтан Хирота Кэй, Сасаки Коухэй, ОУ-ын хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн Такахаши Шоуго, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын Засаглалын салбарын суурин төлөөлөгч А.Сайхантуяа, хөтөлбөрийн ажилтан Ц.Буянжаргал нартай Иргэний хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар болон хоёр талын хамтын ажиллагааны талаарх санал, мэдээлэл солилцсон.
- Ажлын хэсгийн ахлагч 2025.06.16-ны өдөр ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны газрын төлөөлөлтэй Иргэний хуулийг боловсронгуй болгоход судалгааны чиглэлээр хамтран ажиллах тухай санал тавьсны дагуу Иргэний эрх зүйгээр мэргэшсэн Японы Их дээд сургуулийн эрдэмтэн, профессоруудын төлөөлөл урилгыг хүлээн авсан. Ажлын хэсэг 2026 оны I улиралд багтаан гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачид, холбогдох албаны хүмүүсийн оролцоотой Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахаар бэлтгэж байна.



9. Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулагдсан "Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал, дүгнэлт боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.02.27-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн гишүүд дараах 4 хэсэгт хуваагдан ажиллахаар тогтсон. Үүнд:
 - Гадаад зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан;
 - Урсгал зардал-Нийгмийн салбар хариуцсан;
 - Урсгал зардал-Эдийн засаг, дэд бүтцийн салбар хариуцсан;
 - Урсгал зардал-Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн баталгаа, орон тоотой холбоотой асуудал хариуцсан хэсэг.
- Ажлын хэсгийн гишүүд 2025.03.06, 2025.03.14-ний өдрүүдэд Гадаад зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан хэсэгтэй (танхим болон цахимаар) мэдээлэл сонсох уулзалт хийсэн.
- Ажлын хэсэгт 2025.03.26, 2025.03.27-ны өдрүүдэд Сангийн яамнаас мэдээллийг салбар бүрээр танилцуулсан.
- Ажлын хэсгийн 2025.04.29-ний өдрийн хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээллийг сонссон. Мөн хэсгүүдийн санал, дүгнэлтийг хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцсон.
- Ажлын хэсгийн гишүүд 2025.05.18-ны өдөр Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж, Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр”, “Солонго 1, 2” орлогод нийцсэн орон сууцны хорооллын барилгын явцтай танилцав.
- Мөн нийслэлийн нийтийн тээврийн салбарт хэрэгжиж буй дүүжин замын тээврийн төслийн үйл ажиллагаатай танилцсан бөгөөд Улаанбаатар хотод гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн талаар Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай мэдээлэл өгсөн.
- Ажлын хэсгийн 2025.06.25-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн санал дүгнэлт, Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон ажлын хэсгээс өргөн мэдүүлэх хуулийн төслийг хэлэлцсэн.





10. Улсын Их Хурлын даргын 2024 оны 292 дугаар захирамжаар байгуулагдсан "Татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцаж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- "Монгол Улсын татварын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, шинэчлэх хэрэгцээ шаардлага" цуврал хэлэлцүүлгийг "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт" сэдвээр зохион байгуулсан.
- Ажлын хэсгийн 2025.03.21-ний өдрийн хуралдаанд Татварын багц хуулийн хэрэгжилтийн талаарх Сангийн яамны мэдээллийг сонссон.

11. Улсын Их Хурлын даргын 2025 оны 321 дугаар захирамжаар байгуулагдсан "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай" Улсын Их Хурлын 2019 оны 41, "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2020 оны 46, "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай" Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолуудын хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025.08.28-ны өдрийн 102 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн байгалийн нөөц болон дурсгалт газрын хил зааг тогтоохтой холбогдуулан гаргасан мэдээллийг сонсох Улсын Их Хурлын Тамгын газрын холбогдох төлөөллийг оролцуулсан 3 удаагийн уулзалт зохион байгуулсан.
- Ажлын хэсгийн 2025.09.09-ний өдрийн хуралдаанаар "Зарим газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах тухай" Монгол Улсын Их Хурлын 2019 оны 41, 2020 оны 46 дугаар тогтоолуудаар авсан 19 газрын хил заагийг тогтоохтой холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хамтарсан багтай хамтран хэрэгжүүлсэн ажлын талаар болон "Зарим газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэсэн.



ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1.2. Үйл ажиллагаа нь дуусгавар болсон ажлын хэсгийн товч мэдээлэл



1. Улсын Их Хурлын даргын 2024 оны 59 дүгээр захирамжаар байгуулагдсан "Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2024 оны 31 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний санал боловсруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн ахлагч 2025.03.31-ний өдөр хөрс, хүнсний технологийн чиглэлийн эрдэмтэн, судлаач нартай уулзалт хийсэн.
- Төсвийн байнгын хорооны 2025.04.23-ны өдрийн хуралдаанаар Засгийн газраас 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэхтэй холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Б.Баярбаатар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулсанаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

2. Улсын Их Хурлын даргын 2024 оны 79 дүгээр захирамжаар байгуулагдсан "Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсэг 2025.04.28-29-ний өдрүүдэд Дундговь аймгийн Сайнцагаан, Говь-Угтаал, Гурвансайхан сумын ундны ус хангамж, түгээх сүлжээ, ариун цэврийн байгууламжийн нөхцөл байдалтай танилцаж, холбогдох мэдээллийг сонссон. Эрх зүйн орчныг сайжруулах, шинэчлэлт хийх талаар иргэд, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийсэн.
- Ажлын хэсгийн 2025.06.18-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн тайлан, санал, зөвлөмжийн төслийг хэлэлцсэн.
- БОХХААБХ-ны 2025.06.24-ний өдрийн хуралдаанд ажлын хэсгээс тайлан, санал, дүгнэлтээ танилцуулснаар **үйл ажиллагаа нь дуусгавар болсон.**

3. Улсын Их Хурлын даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар байгуулагдсан "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсэг 2025.02.07-09-ний өдрүүдэд Дорнод аймагт ажиллаж залуучуудын эрх, оролцоог сайжруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлуудыг судлах ажлын хүрээнд орон нутгийн залуучуудтай уулзалт хийж, ярилцлага зохион байгуулсан.
- Ажлын хэсэг 2025.03.11, 2025.03.18, 2025.04.04-ний өдрүүдэд Ханнс-Зайделийн сан, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэргэдэх Герман, Европын эрх зүйн төвийн төлөөлөлтэй хуулийн судалгааны ажлын даалгаврын төслийн талаар хэлэлцэж, судалгааны ажлын талаар санал солилцсон.



- Ажлын хэсгийн 2025.04.16-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн тайлангийн төсөлд санал авах, салбарын яаманд хуулийн төсөл боловсруулахтай холбоотой чиглэл өгөх асуудлыг хэлэлцсэн.
- Ажлын хэсгийн 2025.05.07-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн үйл ажиллагааны тайлан, санал, дүгнэлт, Засгийн газарт чиглэл өгөх тухай шийдвэрийн төслийг хэлэлцсэн.
- Ажлын хэсэгт 2025.05.23-ны өдөр НҮБ-ын Хүн амын сангаас Залуучуудын нөхцөл байдлын шинжилгээний тайлан болон Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны стратегийг тус тус танилцуулсан.
- Ажлын хэсгийн 2025.05.28, 2025.06.25-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн.
- НББХ-ны 2025.07.08-ны өдрийн хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлсэн. Байнгын хорооноос 2025.07.08-ны өдрийн 10 дугаар тогтоолыг баталснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

4. Улсын Их Хурлын даргын 2024 оны 82 дугаар захирамжаар байгуулагдсан "Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Дорноговь аймгийн Сайншанд суманд “Өрхийн болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, хууль тогтоомжийг шинэчлэх хэрэгцээ шаардлага” сэдэвт хэлэлцүүлгийг 2025.04.10-ны өдөр АҮББХ-ны 2025 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулсан.
- Ажлын хэсэг 2025.05.05-ны өдөр тулгамдаж буй асуудал, шинэ тутам үүсэж буй эрх зүйн харилцаа, түүний зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сайжруулах талаар Нийслэлийн 9 дүүргийн төрийн болон ТББ, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- АҮББХ-ны 2025 оны 02 дугаар тогтоол, БОХХААБХ-ны 2025 оны 02 тогтоолоор тус тус байгуулагдсан ажлын хэсгүүдийн 2025.06.05-ны өдрийн хамтарсан хуралдаанаар Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, бусад улсын туршлагын талаар ПСХХ, Хөгжлийн шийдэл ТББ-аар хийлгэсэн судалгааны тайланг сонссон.
- Ажлын хэсгийн дэмжих багийн 2025.06.10-ны өдрийн хуралдаанаар хамтарсан хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу ажлын хэсгүүдийн саналуудыг нэгтгэн хуулийн төсөлд тусгах саналын талаар хэлэлцсэн.
- Ажлын хэсгийн 2025.06.18-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцсэн.
- **Ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болсон.**



5. Улсын Их Хурлын даргын 2024 оны 113 дугаар захирамжаар байгуулагдсан "Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн ахлагч 2025.03.31-ний өдөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга С.Энхболдтой уулзалт хийсэн.
- Ажлын хэсэг 2025.04.22-ны өдөр ЭМДЕГ-т ажиллаж, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх улсын төсөв, ЭМД-ын нэгдсэн сангийн бодит нөхцөл байдал, хийгдсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүн болон эрт илрүүлгийн идэвх оролцоог сайжруулах, даатгалын тогтолцооны ОУ-ын дэвшилтэт аргачлалаас туршлага судлах зэрэг асуудлыг хэлэлцсэн.
- Ажлын хэсгийн 2025.04.24-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар эрүүл мэндийн салбарын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийсэн талаарх танилцуулга, актуар тооцооллын мэдээллийг сонссон.
- Ажлын хэсгийн 2025.04.25-ны өдрийн хуралдаанаар ЭМДҮЗ-ийн үйл ажиллагаа, бодлогын шийдвэрүүд, цаашид анхаарах асуудлаар мэдээлэл сонссон
- Ажлын хэсгийн 2025.07.08-ны өдрийн хуралдаанаар санал, дүгнэлтийн төслийг эцэслэн хэлэлцэж, санал, дүгнэлтээ УИХ-ын даргад танилцуулснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

6. Улсын Их Хурлын даргын 2025 оны 243 дугаар захирамжаар байгуулагдсан "Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2024 оны 31 дүгээр тогтоолын хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар "Улаанбуудай, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл", "Буудайн гурилын үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийгдсэн судалгаа, хяналт шалгалт", "Улаан буудай, гурилын салбарын өрсөлдөөний төлөв" зэрэг сэдвээр Үндэсний статистикийн хороо, Монополын эсрэг газрын мэдээлэл, судалгааны тайлан болон Улсын Их Хурлын даргын 2024 оны 59 дүгээр захирамжаар байгуулагдан ажилласан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонссон.
- Засгийн газраас яаралтай горимоор өргөн мэдүүлсэн "Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай" хуулийн төслийг 2025.06.25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Түүнчлэн "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолыг баталснаар "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2024.04.19-ний өдрийн 31 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон. Ажлын хэсгийн ахлагчийн 2025.07.01-ний өдрийн ТГ-03/8249 дүгээр албан бичгээр Улсын Их Хурлын даргын 2025 оны 243 дугаар захирамжийг хүчингүй болгох хүсэлтийг Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн.
- **Ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болсон.**

ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 4. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо		
1.	2024.11.13 №01 ТОГТООЛ “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Л.Мөнхбаясгалан Гишүүд: М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг, Х.Жангабыл, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин
2.	2024.11.19 №05 ТОГТООЛ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтуяа Гишүүд: М.Бадамсүрэн, П.Мөнхтулга, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Г.Лувсанжамц, Д.Пүрэвдаваа, Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг
3.	2024.11.13 №02 ТОГТООЛ “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбаатар Гишүүд: М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг, Х.Жангабыл, Г.Лувсанжамц, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Г.Очирбат, Б.Тулга, Б.Уянга, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг
4.	2024.12.24 №08 ТОГТООЛ Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Б.Уянга Гишүүд: Д.Батлут, Д.Батбаяр, Д.Жаргалсайхан, Ж.Золжаргал, С.Замира, Г.Лувсанжамц, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, М.Энхцэцэг
5.	2025.01.15 №02 ТОГТООЛ Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: М.Бадамсүрэн Гишүүд: Д.Батбаяр, П.Ганзориг, М.Ганхүлэг, Х.Жангабыл, Г.Лувсанжамц, С.Замира, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, Д.Энхтуяа
6.	2025.04.02 №06 ТОГТООЛ Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны нөөцийн зөв зохистой ашиглалт, усны ашиглах боломжит нөөц, ус хэрэглээний хэтийн төлөв, ус ашигласны болон ус бохирдуулсны үнэ, төлбөр, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: П.Ганзориг Гишүүд: С.Ганбаатар, Ж.Золжаргал, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Б.Тулга, Б.Уянга
7.	2025.04.16 №07 ТОГТООЛ /Ашигт малтмалын тухай хууль шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн биелэлтийг хангуулах болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нутгийн захиргааны байгууллагатай эрхэн харьцаж байгаа асуудлын талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: С.Замира Гишүүд: С.Ганбаатар, М.Бадамсүрэн, С.Лүндэг, О.Батнайрамдал, Б.Уянга, Э.Болормаа, Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, П.Сайнзориг,
8.	2025.04.30 №09 ТОГТООЛ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцыг шалган судлах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Д.Үүрийнтуяа Гишүүд: М.Бадамсүрэн, Д.Батбаяр, С.Замира, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Г.Очирбат, Б.Уянга, Д.Энхтуяа, М.Энхцэцэг
9.	2025.05.22 №11 ТОГТООЛ Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэржилтийн өсөлт, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох, үйл ажиллагааг эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбаатар Гишүүд: М.Бадамсүрэн, П.Ганзориг, Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, Б.Тулга

ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо		
10.	2024.10.15 №01 ТОГТООЛ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.1-д тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол зорилтын хүрээнд туссан Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Ч.Ундрэм Гишүүд: Ц.Мөнхтуяа, Д.Рэгдэл, М.Сарнай, О.Саранчулуун, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат
11.	2024.10.15 №02 ТОГТООЛ Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: О.Батнайрамдал Гишүүд: Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, Г.Дамдинням, Б.Найдалаа, М.Сарнай, О.Саранчулуун, С.Эрдэнэбат
12.	2025.01.14 №01 ТОГТООЛ Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, биелэлтэд хяналт шалгалт хийх, шаардлагатай бол холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулан хэлэлцүүлэх бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Г.Дамдинням Гишүүд: Ш.Бямбасүрэн, А.Ганбаатар, О.Саранчулуун, Г.Хосбаяр, С.Эрдэнэбат
Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны		
13.	2025.01.14 №02 ТОГТООЛ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Бат-Эрдэнэ Гишүүд: М.Бадамсүрэн, С.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, У.Отгонбаяр
14.	2025.01.21 №04 ТОГТООЛ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбаатар Гишүүд: М.Ганхүлэг, С.Замира, М.Мандхай, А.Ундраа, Б.Уянга, Р.Сэддорж
15.	2025.03.25 №07 ТОГТООЛ Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг <i>/Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай/</i>	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Батжаргал Гишүүд: Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, Б.Найдалаа, Н.Наранбаатар, Ц.Мөнхбат, П.Батчимэг, С.Лүндэг
16.	2025.05.28 №13 ТОГТООЛ Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт, шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: М.Ганхүлэг Гишүүд: М.Бадамсүрэн, С.Ганбаатар, С.Замира, У.Отгонбаяр
Инновац, цахим бодлогын байнгын хороо		
17.	2025.05.06 №05 ТОГТООЛ Шуудангийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн журмын биелэлтийг хянан шалгах, шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтыг сайжруулах, цахим худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх талаар санал, дүгнэлт гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Ц.Мөнхбат Гишүүд: Ч.Анар, Б.Заяабал, Ц.Идэрбат, П.Мөнхтулга, Б.Пунсалмаа, Р.Сэддорж, Ч.Ундрэм, С.Цэнгүүн

Төсвийн байнгын хороо

18.	2025.01.22 №03 ТОГТООЛ “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай холбогдуулан шалгалтад хамрагдсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтэц, зохион байгуулалт, геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой болгох болон геологийн салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Б.Заяабал Гишүүд: Ж.Батжаргал, Ж.Баясгалан, Г.Ганбаатар, Г.Дамдинням
-----	---	--

Эдийн засгийн байнгын хороо


19.	2025.04.16 №2 ТОГТООЛ “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Л.Соронзонболд Гишүүд: Ж.Алдаржавхлан, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Б.Мөнхсөөл, Б.Найдалаа, П.Батчимэг, Э.Болормаа
20.	2025.06.10 №06 ТОГТООЛ Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа Орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Алдаржавхлан Гишүүд: Р.Сэддорж, Н.Батсүмбэрэл, Ш.Бямбасүрэн, Г.Лувсанжамц, М.Мандхай, П.Сайнзориг, А.Ундраа
21.	2025.06.10 №7 ТОГТООЛ Монголбанк дахь Үндэсний баялгийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: О.Батнайрамдал Гишүүд: Р.Сэддорж, М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Б.Жаргалан, Б.Мөнхсөөл, П.Сайнзориг, Д.Энхтүвшин



Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд ажилласан ажлын хэсгийн мэдээлэл.

2.2.1. Үйл ажиллагаа нь үргэлжилж буй ажлын хэсгийн товч мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйл



1. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах талаар Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг хэлэлцүүлсэн. АҮББХ-ны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2025 оны 05 дугаар тогтоолыг баталсан.
- Ажлын хэсгийн 2025.04.01-ний өдрийн хуралдаанаар дэд хэсгийн ажлыг эрчимжүүлэх талаар болон ижил төстэй үйлдвэрүүдтэй танилцах ажлыг зохион байгуулахтай холбоотойгоор гадаад улс, орны газрын тосны үйлдвэрийн судалгаа хийх зэрэг асуудлыг хэлэлцсэн.
- Ажлын хэсэг 2025.04.08-10-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Алтанширээ суманд байрлах Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт, Сайншанд суманд байрлах үйлдвэрийн ажилчдын 550 айлын орон сууцны явц байдалтай газар дээр нь танилцаж, үйлдвэрийн удирдлага, ажилчидтай уулзалт хийсэн.

2. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор байгуулагдсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн ахлагч, дэмжих бүрэлдэхүүний төлөөллийн хамт 2025.02.11-ний өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдлагуудтай уулзаж, мэдээлэл солилцсон.
- Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн С.Ганбаатар, УИХ-ын гишүүн Б.Уянга, П.Мөнхтулга нар 2025.02.19-20-ны өдрүүдэд Өмнөговь аймагт ажиллаж, Нүүрс баяжуулах үйлдвэр болон бусад бүтээн байгуулалтын төслүүдтэй танилцсан.
- Ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүний боловсруулсан санал, дүгнэлттэй 2025.03.25-ны өдөр танилсан.

3. Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Байнгын хорооны 2025.03.25-ны өдрийн 08 дугаар тогтоолоор ажлын хэсгийн удирдамжыг баталсан.
- Ажлын хэсгийн 2025.04.30-ны өдрийн хуралдаанаар Жижиг, дунд үйлдвэрийн газраас танилцуулсан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн олгосон зээлийн хэмжээ, нөхцөл, зээлийн эргэн төлөлтийн байдал, сангийн төсөвт үзүүлж буй нөлөөлөл, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл сонсож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлөөллийн саналыг сонссон.
- БОХХААБХ-ны 2025 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг, Улсын Их Хурлын даргын 2024 оны 82 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгтэй 2025.06.05-ны өдөр хамтран хуралдаж, санал солилцсон.



4. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор байгуулагдсан “Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны нөөцийн зөв зохистой ашиглалт, усны ашиглах боломжит нөөц, ус хэрэглээний хэтийн төлөв, ус ашигласны болон ус бохирдуулсны үнэ, төлбөр, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- АҮББХ-ны 2025.04.16-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн удирдамжийг хэлэлцэж, 08 дугаар тогтоолоор баталсан.
- Ажлын хэсгийн гишүүд 2025.05.07-ны өдөр усны салбарын нөхцөл байдлын талаар Усны газрын дарга З.Батбаяртай уулзалт хийсэн.
- Ажлын хэсгийн 2025.05.27-ны өдрийн хуралдаанаар Усны газрын мэдээллийг сонссон.

5. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, биелэлтэд хяналт шалгалт хийх, шаардлагатай бол холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулан хэлэлцүүлэх бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн удирдамжийн төслийг хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

6. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор байгуулагдсан “Ашигт малтмалын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн биелэлтийг хангуулах болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нутгийн захиргааны байгууллагатай хэрхэн харьцаж байгаа асуудлын талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- АҮББХ-ны 2025.05.06-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн удирдамжийг хэлэлцэж, 10 дугаар тогтоолоор баталсан.
- Ажлын хэсгийн 2025.05.07-ны өдрийн хуралдаанаар ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн.
- ХЗДХЯ-ны Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлөөс Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.13-д заасан нээлттэй мэдээллийн 2024 оны үнэлгээг гаргуулан авсан.
- Ажлын хэсгийн 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар АМГТГ-ын болон Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилагын ажлын албаны мэдээллийг тус тус сонссон.



7. Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолоор байгуулагдсан “Шуудангийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн журмын биелэлтийг хянан шалгах, шуудан түгээлтийн сүлжээний ашиглалтыг сайжруулах, цахим худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх талаар санал, дүгнэлт гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.05.16-ны өдрийн хуралдаанаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монгол шуудан ХК-ийн мэдээлэл сонссож, хуралдаанд оролцсон ТББ-ын төлөөлөл, байгууллагуудаас тайлбар, тодруулга хийсэн. Ажлын хэсгийн ахлагчаас дээрх байгууллагуудыг тус салбарын эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны цаашдын чиг хандлагын талаарх саналаа ирүүлэхийг үүрэг болгосон.



8. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын 2025 оны 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэржилтийн өсөлт, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох, үйл ажиллагааг эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- АҮББХ-ны 2025.05.11-ний өдрийн хуралдаанаар удирдамжийн төслийг хэлэлцэж, 11 дүгээр тогтоолоор баталсан.
- Ажлын хэсгийн ахлагч 2025.06.16-ны өдөр хил орчмын бүсэд худалдаа эрхлэх, хил, гааль, экспортын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлаар санал, мэдээлэл авах зорилгоор бизнес эрхлэгчдийн төлөөлөл, МҮХАҮТанхим, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-н төлөөлөлтэй уулзалт хийлээ.
- Ажлын хэсгийн 2025.06.18-ны өдрийн хуралдаанаар ажлын төлөвлөгөөний төсөл, ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж хамтран ажиллах бүрэлдэхүүний талаар хэлэлцсэн.



9. Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор байгуулагдсан “Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа Орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- ЭЗБХ-ны 2025.06.25-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн удирдамжийн төслийг хэлэлцэж, 10 дугаар тогтоолоор баталсан.

10. Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор байгуулагдсан “Монголбанк дахь Үндэсний баялгийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- ЭЗБХ-ны 2025.06.25-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн удирдамжийн төслийг хэлэлцэж, 09 дүгээр тогтоолоор баталсан.



2.2.2. Үйл ажиллагаа нь дуусгавар болсон ажлын хэсгийн товч мэдээлэл



1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан "Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- БСШУСБХ-ны 2025.03.26-ны өдрийн хуралдаанаар Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг сонсож, ажлын хэсгийн ахлагчаас ажлын хэсгийн санал, дүгнэлтээ танилцууллаа.
- Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ыг боловсронгуй болгох ажлын хүрээнд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан Байнгын хорооны 03 дугаар тогтоол баталснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

2 Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 08 дугаар тогтоолоор байгуулагдсан "Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.04.01-ний өдрийн хуралдаанаар "Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн өнөөгийн нөхцөл байдал, холбогдох санал, дүгнэлт"-ийн талаарх танилцуулгыг "Эрдэнэс УТП" ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Мөнх-Идэр, "Үйлдвэрлэл, технологийн паркийн гадны туршлага /БНСУ, БНХАУ, ТУРК/"-ын талаар Монголын үйлдвэрлэл, технологийн паркуудын нэгдсэн холбооны тэргүүн, доктор Б.Батгэрэл нар танилцуулсан.
- Ажлын хэсгийн ишүүд 2025.04.19-23-ны өдрүүдэд БНХАУ-ын Жэжян мужийн Ханжөү хот, ӨМӨЗО-ны Хөх хот дахь Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах ажлын айлчлал хийж, Хөх хотын өндөр технологийн паркууд болон Ханжөү хотын инновацийн төвүүдээр зочилж, үйл ажиллагаа, бүтцийн онцлог, төрхувийн хэвшлийн түншлэл, кластер хөгжлийн загвар зэргийг судалсан.

Мөн ажлын хэсгийн гишүүд тус бүс нутаг дахь ШУ, технологийн хөгжил, инновацийн экосистем, үйлдвэрлэл, менежментийн загваруудтай танилцаж, Монгол Улсад нутагшуулах боломжтой туршлага, шийдлүүдийг судалж ажилласан.

- Ажлын хэсгээс 2025.06.10-ны өдөр "ITP-Forum 2025" Үйлдвэрлэл, технологийн паркийн форум зохион байгуулсан. Форумын хүрээнд салбар хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн Байнгын хорооны даргад танилцуулахаар хүргүүлсэн.
- Ажлын хэсгийн 2025.06.18-ны өдрийн хуралдаанаар "Үйлдвэрлэл, технологийн паркийн форум 2025" хэлэлцүүлгийн тайлан, мэдээллийг "Эрдэнэс УТП" ХХК-ын гүйцэтгэх захирал Н.Мөнх-Идэр танилцуулсан. Мөн дотоодын Үйлдвэрлэл, технологийн парктай очиж танилцах ажлын хэсгийн удирдамжийн төслийг хэлэлцсэн.
- АҮББХ-ны 2025.06.24-ний өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн явц, түүнчлэн "Үйлдвэрлэл технологийн паркийн хэлэлцүүлэг"-ээс гарсан санал, зөвлөмжид үндэслэн боловсруулсан Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг хэлэлцэн, баталснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**





3. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, зарим нэмэлт материалыг татан авч судлах, тогтоолын төслийг гишүүдэд танилцуулахыг дэмжих багт чиглэл болгосон. Дэмжих багийн гишүүд “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаатай холбоотой 23 багц материал, 5 стандарт зэрэг материалуудтай танилцаж, дүн шинжилгээ хийсэн.
- 2025 оны 4 дүээр сард Нийслэлийн ИТХ-ын даргын захирамжаар байгуулагдсан “Тавантолгой түлш” ХХК-ийн боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгээс мэдээлэл авсан.
- Дэмжих багийн гишүүд нийт 17 удаагийн уулзалт хийж, ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийн төсөл болон санал, дүгнэлтэд үндэслэн Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан ажлын хэсэгт танилцуулсан.
- Ажлын хэсгийн 2025.06.05-ны өдрийн хуралдаанаар тайлан, санал, дүгнэлтийн төсөл болон Засгийн газарт чиглэл өгөх Байнгын хорооны шийдвэрийн төслийг хэлэлцсэн.
- БОХХААБХ, АҮББХ-ны 2025.06.24-ний өдрийн хамтарсан хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулсан.
- АҮББХ-ны 2025.07.01-ний өдрийн хуралдаанаар Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**



4. Төсвийн байнгын хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай холбогдуулан шалгалтад хамрагдсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтэц, зохион байгуулалт, геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой болгох болон геологийн салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулах асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн үйл ажиллагаа:

- ТБХ-ны 2025.03.17-ны өдөр ажлын хэсгийн удирдамжийн төслийг боловсруулж, ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан.
- Ажлын хэсгийн 2025.06.05-ны өдрийн хуралдаанаар Үндэсний геологийн албаны эрдэс баялагийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэгийн хийсэн мэдээлэлийг сонссон.
- Байнгын хорооны 2025.07.08-ны өдрийн хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, чиглэл өгөх шийдвэрийн төслийг хэлэлцүүлсэн.
- Байнгын хорооны 2025 оны 19 дүгээр тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөнөөр **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**





5. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан “Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсэг 2025.02.03-07-ны өдрүүдэд зүүн бүсийн ЖДҮ-ийн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, ЖДҮ эрхлэгчдээс судалгаа авч, үр дүнг нэгтгэв.
- Ажлын хэсгийн 2025.02.11-ний өдрийн хуралдаанаар зүүн бүсийн хэлэлцүүлгийн үр дүнгийн тайлан, мэдээллийг сонсов.
- 2025.04.15-05.10-ны өдрүүдэд ЖДҮГ, Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран 21 аймгийн 881 ЖДҮ эрхлэгчдээс “Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээл, хууль эрх зүйн шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага” сэдвээр санал асуулга авч, дүгнэв.
- Ажлын хэсгийн 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар Хөгжлийн шийдэл ТББ-ын гэрээт ажлын тайлан, Байнгын хороонд танилцуулах ажлын хэсгийн санал, дүгнэлтийн төслийг хэлэлцсэн.
- Тус ажлын хэсэг болон БОХХААБХ-ны 2025 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг, Улсын Их Хурлын даргын 2024 оны 82 дугаар захирамжаар байгуулагдсан 3 ажлын хэсэг 2025.06.05-ны өдөр хамтран хуралдаж, санал солилцсон.
- АҮББХ-ны 2025.06.24-ний өдрийн хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, санал, дүгнэлтэд үндэслэн боловсруулсан Засгийн газарт чиглэл өгөх тухай 14 дүгээр тогтоолыг баталснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

6. Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор байгуулагдсан “Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа: /Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай/

- Ажлын хэсгийн 2025.04.02-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын зарим удирдлагатай УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг үнэлэх, ажлын хэсэгт мэдээлэл хийх асуудлаар ярилцсан.
- Ажлын хэсгийн 2025.04.09-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд хийсэн үнэлгээний явцын тайланг сонссон.

Тус тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл ирүүлэхийг хүссэн албан бичгийг холбогдох 7 яам, 2 агентлагт хүргүүлж, хариуг авсан.

- БОХХААБХ-ны 2025.04.15-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн удирдамжийг хэлэлцэж, 10 дугаар тогтоолоор баталсан.
- Ажлын хэсгийн 2025.04.30-ны өдрийн хуралдаанаар тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан Сангийн яам, ХХААХҮЯ, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээлэл сонссон.
- Ажлын хэсэг 2025.05.07-ны өдөр Сангийн яам, Монголбанкны төлөөлөлтэй уулзаж, нэмэлт мэдээлэл сонссон.
- Ажлын хэсгийн 2025.05.15-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн санал, дүгнэлт гаргах ажлын хүрээнд ХХААХҮЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж, санал солилцсон.
- АҮББХ-ны 2025.05.21-ний өдрийн хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Байнгын хорооны 2025 оны 12 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөнөөр **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**



7. Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.04.30, 2025.05.10-ны өдрийн хуралдааныг Монголбанкны байранд зохион байгуулсан бөгөөд холбогдох 10 байгууллага, судлаачидийн төлөөлөл нийт 43 оролцогч танхимаар болон цахимаар оролцсон. Хуралдаанаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамны мэдээлэл, тайланг сонсож, мэдээлэл солилцсон.
- Ажлын хэсгийн гишүүд 2025.05.15-ны өдөр үйл ажиллагааны хүрээнд санал солилцох уулзалт хийсэн.
- Ажлын хэсгийн 2025.05.21-ний өдрийн хуралдаанаар Монголын банкуудын холбоо, Монголын ББСБ-уудын холбоо, Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбоодын төлөөлөлтэй уулзаж стратегийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсож, дээрх санхүүгийн салбарын холбоодын бэлтгэсэн санал, дүгнэлттэй танилцсан.
- Зээлийн хүүг бууруулах асуудлын хүрээнд эдийн засагч, судлаачдын гаргасан саналыг хэлэлцүүлэх зорилгоор Ажлын хэсгээс 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Ажлын хэсгийн 2025.06.16, 2025.06.23-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн тайлан, санал дүгнэлт, Байнгын хорооны хуралдаанд танилцуулах тогтоолын төслийг хэлэлцсэн.
- ЭЗБХ-ны 2025.06.25-ны өдрийн хуралдаанд ажлын хэсэг тайлангаа танилцуулж, холбогдох байгууллагад чиглэл өгөх Байнгын хорооны шийдвэрийн төслийг хэлэлцүүлсэн.
- ЭЗБХ-ны 2025.06.30-2025.07.07-ны өдрийн хуралдаанаар “Зээлийн хүүг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийг хэлэлцэж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.
- Улсын Их Хурлын чуулганы 2025.07.08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн боловсруулсан шийдвэрийн төслийг хэлэлцүүлж, 76 дугаар тогтоолыг баталснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

8. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцыг шалган судлах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- Ажлын хэсгийн 2025.05.27-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн ерөнхий зохион байгуулалтын талаар болон мега төслүүдийг гишүүдэд хуваарилан хариуцуулах, хариуцсан төслийн үйл явцтай танилцах, цаашид холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах талаар хэлэлцсэн.
- Монгол Улсын Их Хурлын тухай хуульд оруулсан 2025.07.09-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр тус Байнгын хорооны эрхлэх асуудлыг ЭЗБХ-ны эрхлэх асуудалд нэмсэнтэй холбогдуулан ажлын хэсгийг УИХ-ын даргын 2025 оны 365 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан тул тус **ажлын хэсгийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцсон.**




9. Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 13 дугаар тогтоолоор байгуулагдсан “Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт, шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- БОХХААБХ-ны 2025.06.03-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн удирдамжийг хэлэлцэж, 14 дүгээр тогтоолоор баталсан.
- Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд хэсгийн 2025.06.05-ны өдрийн хуралдаанаар ХХААХҮЯ, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонссон.
- Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд хэсгийн 2025.06.19-ний өдрийн хуралдаанд ажлын хэсгийн гишүүд оролцож ажлын хэсгийн санал, дүгнэлт, түүнд үндэслэн боловсруулсан шийдвэрийн төслийг эцэслэн хэлэлцсэн.
- Ажлын хэсгийн 2025.06.23-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн санал, дүгнэлт, түүнд үндэслэн боловсруулсан УИХ-ын шийдвэрийн төслийг хэлэлцэж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.
- БОХХААБХ-ны 2025.06.24-ний өдрийн хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, санал, дүгнэлтэд үндэслэн боловсруулсан шийдвэрийн төслийг хэлэлцүүлсэн. Байнгын хороо шийдвэрийн төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.
- Улсын Их Хурлын чуулганы 2025.07.04-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн боловсруулсан шийдвэрийн төслийг хэлэлцүүлж, Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын 2025 оны 73 дугаар тогтоолыг баталснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

10. Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- БОХХААБХ-ны 2025.01.21-ний өдрийн 05 дугаар тогтоолоор ажлын хэсгийн удирдамжийг баталсан.
- Ажлын хэсгийн ахлагч 2025.01.21-ний өдөр ажлын хэсгийн төлөвлөгөөг баталж, Байнгын хорооны ажлын албатай 3 удаа, дэмжих багтай 1 удаа уулзалт хийсэн. Уулзалтын үеэр олон улсын зээл тусламж болон зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаар танилцуулсан.
- Ажлын хэсгийн ахлагчаас 2025.03.13-ны өдөр дэмжих багтай хийсэн уулзалтын хүрээнд ХХААХҮЯ, БОУАӨЯ, СЯ, ҮАГ-ын олон улсын зээл тусламж болон зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга сонссон.
- Ажлын хэсгийн 2025.05.28-ны өдрийн хуралдаанаар ХХААХҮЯ, БОУАӨЯ-дад олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг сонсож, танилцуулга, санал дүгнэлтийг нэмж, сайжруулах чиглэл өгсөн.
- Ажлын хэсгийн санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг БОХХААБХ-ны 2025.07.07-ны өдрийн хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсэн. **Ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**



11. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.1-д тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол зорилтын хүрээнд туссан Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаа:

- БСШУСБХ-ны гишүүд 2025.04.19-23-ны өдрүүдэд Төв, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгуудад ажиллаж, аймгийн МСҮТ, ЕБС, СӨБ-ын байгууллагын удирдах ажилтнуудтай уулзаж, тэдний гаргасан хүсэлт, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцсон.
- Мөн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Боловсролын салбарт жил бүр 100-гаас доошгүй нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтын 4 үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа ажлын явцтай танилцсан.
- Ажлын хэсгийн 2025.04.30-ны өдрийн хуралдаанаар явцын тайлан, орон нутагт ажилласан тайланг сонссон. Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.
- БСШУСБХ-ны 2025.05.07-ны өдрийн хуралдаанаар Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг хэлэлцэж, 04 дгээр тогтоолыг баталсан.
- Ажлын хэсэг 2025.05.12-ны өдөр тус төслийн ажлыг гүйцэтгэгч байгууллагуудтай төслийн хэрэгжилтийн явц, тулгамдаж буй асуудал, төслийг үр дүн, тогтсон хугацаанд дуусгах, ашиглалтын явцад гарч буй алдаа, дутагдлыг залруулж, цаашид ашиглалтыг сайжруулах асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг хийсэн.
- **Ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**



Монгол Улсын Их Хурлын тухай
хуулийн 8 дугаар зүйл 8.1.13,
37 дугаар зүйл.

Монгол Улсын Их Хурлын хяналт
шалгалтын тухай хуулийн
11 дүгээр зүйл, 12 дугаар зүйл

Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад хандан 2025 оны хаврын ээлжит чуулганы болон хаврын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 10 гишүүн 48 асуудлаар 8 удаа асуулга, давхардсан тоогоор Улсын Их Хурлын 12 гишүүн 40 асуудлаар 10 удаа асуулт тавьсан байна.

Хүснэгт 5.Улсын Их Хурлын гишүүний асуулга

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА						
Д/д	УИХ-ын гишүүний нэр	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуулгын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Асуулт тавьсан огноо	Хариу ирүүлсэн огноо
1.	Б.Хэрлэн	Боловсролын сайд П.Наранбаяр	Боловсролын бодлого, үйл ажиллагаанд тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх талаар	2	2025.03.21 №12	хариу ирүүлэх хугацаа 2025.04.21
2	Г.Тэмүүлэн Ж.Чинбүрэн	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар	4	2025.03.28 №14	2025.04.30 ХЭГ/1174
3.	О.Амгаланбаатар	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын талаар	3	2025.04.25 №18	2025.05.30 ХЭГ/1570
4.	Ж.Батжаргал	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Хуулийн хэрэгжилтийн талаар /Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай/	7	2025.04.29 №19	2025.05.30 ХЭГ/1571
5.	Д.Үүрийнтуяа	Боловсролын сайд П.Наранбаяр	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар	2	2025.05.06 №20	2025.06.06 1/2564
6.	М.Бадамсүрэн	Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан	Өндөрхаан - Чойбалсан чиглэлийн авто замын талаар	6	2025.06.18 №22	хариу ирүүлэх хугацаа 2025.07.18
7.	Ч.Ундрам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр	Органик бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн талаар	10	2025.06.20 №23	хариу ирүүлэх хугацаа 2025.07.20
8.	Б.Бат-Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Боловсролын хуулийн зарим заалтын хэрэгжилтийн талаар	14	2025.07.07 №27	2025.08.19 ХЭГ/2207
9.	С.Цэнгүүн	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Эрчим хүчний реформын талаар	13	2025.08.12 №28	2025.09.15 ХЭГ/2498
10.	Х.Баасанжаргал	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар	8	2025.08.14 №29	2025.09.12 ХЭГ/2495
11.	Ч.Лодойсамбуу	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Төсвийн тухай хуулийн хэрэгжилт болон Улсын Их Хурлын гишүүдээс тойргийн хөрөнгө оруулалтад санал авсан талаар	8	2025.08.18 №31	2025.09.17 ХЭГ/2543
12.	С.Эрдэнэболд	Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн	Эрүүл монгол хүний эрхийн баталгааг хангах талаар	4	2025.08.26 №34	2025.09.29 10/4705
13.	С.Эрдэнэболд	Боловсролын сайд П.Наранбаяр	Боловсролтой монгол хүний баталгааг хангах талаар	4	2025.08.28 №35	2025.09.12 1/4184

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ						
д/д	УИХ-ын гишүүний нэр	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуултын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Асуулт тавьсан огноо	Хариу ирүүлсэн огноо
1.	Г.Лувсанжамц	Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн	Орон сууцны ипотекийн зээлийн зохицуулалтын талаар	3	2025.02.10 №10	2025.03.14 А-1/212
2	Ж.Галбадрах	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар	3	2025.03.11 №11	2025.04.07 01/1178
3.	П.Сайнзориг Б.Энхбаяр З.Мэндсайхан	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Асуулт тавих тухай /төрийн байгууллагын талаар/	3	2025.03.28 №13	2025.04.11 ХЭГ/995
4.	А.Ариунзаяа	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар	3	2025.04.03 №15	2025.04.18 01/1264
5.	Г.Тэмүүлэн	Сангийн сайд Б.Жавхлан	Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалтын талаар	7	2025.04.03 №16	2025.04.17 01/2979
6.	О.Батнайрамдал	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Асуулт тавих тухай /Оюу Толгой ордтой холбоотой асуудлаар/	10	2025.04.10 №17	2025.05.05 ХЭГ/1268
7.	Д.Үүрийнтуяа	Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн	Эрчим хүчний тарифын зохицуулалтын талаар	1	2025.05.23 №21	2025.06.06 а/1825
8.	Ж.Золжаргал	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	3	2025.06.20 №24	2025.08.20 ХЭГ/2220
9.	П.Сайнзориг	Монгол банкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн	Монголбанкнаас арилжааны банканд тавих хяналтын талаар	4	2025.06.27 №25	2025.08.19 А-1/650
10.	П.Сайнзориг	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц	Санхүүгийн зохицуулах хороо хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар	1	2025.06.27 №26	2025.08.12 1/3066
11.	Г.Лувсанжамц	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Агаарын бохирдлыг бууруулах төсөл хөтөлбөрүүдийн талаар	4	2025.07.25 №27	2025.08.18 ХЭГ/2198
12.	Ц.Мөнхтуяа	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар	3	2025.08.19 №30	2025.09.02 ХЭГ/2364
13.	Ц.Мөнхтуяа	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	2	2025.08.20 №32	2025.09.04 01/1536
14.	С.Эрдэнэболд	Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн	Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн талаар	3	2025.08.26 №33	2025.09.10 №2675
15.	Л.Мөнхбаясгалан	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Төрийн албаны реформын талаар	2	2025.09.15 №36	Хугацаа болоогүй
16.	Л.Мөнхбаясгалан	ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогт	Эрчим хүчний үнэ тариф, салбарын бодлогын хэрэгжилтийн талаар	2	2025.09.15 №37	хариу ирүүлэх хугацаа 2025.09.29

Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн
113 дугаар зүйл, 114 дүгээр зүйл



3.1.АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

- НББХ-ны 2025.05.13-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн нараас “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар асуулга хүргүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж тавьсан 14 дүгээр асуулгын хариуг хэлэлцсэн.


3.2.АСУУЛТЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүний асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн байдал:

- БСШУСБХ-ны 2025.03.26-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд “Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар” Боловсролын сайд П.Наранбаярт хандаж тавьсан 01 дүгээр асуултын хариуг;
- НББХ-ны 2025.05.07-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд хандаж тавьсан 15 дугаар асуултын хариуг тус тус сонссон.
- <https://www.parliament.mn/nc/624/>

ДӨРӨВ.ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн
тухай хуулийн 112 дугаар зүйл



4.1.ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд 4 удаа мэдээлэл хийсэн. Үүнтэй холбогдуулан давхардсан тоогоор Улсын Их Хурлын 24 гишүүн 62 асуулт асууж, үг хэлсэн байна.Энэ хугацаанд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотойгоор нийт 25 иргэнээс 65 асуулт ирүүлж, хариулт авсан.

- 2025.03.28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд "Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний талаар Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ мэдээлэл хийв.
- 2025.04.25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ мэдээлэл хийв.
- 2025.05.30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Боловсролын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа” сэдвээр Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулсан.
- 2025.06.27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажил”-ын талаар Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар мэдээлэл хийв.

4.2.БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР СОНССОН ТАЙЛАН, ИЛТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ

Ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороодын хуралдаанаар Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад байгууллагын нийт 36 удаагийн тайлан, илтгэл, мэдээлэл сонсож, хэлэлцсэн бөгөөд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 298 гишүүн 834 асуулт асууж, үг хэлсэн байна.



5.1.УЛСЫН ИХ ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хууль, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл болгосон УИХ-ын шийдвэрийн биелэлтэд дүн шинжилгээ хийсэн талаар:



- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д Улсын Их Хурлаас Засгийн газар, УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон УИХ-ын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө УИХ-д ирүүлэхээр заасан. Засгийн газраас ирүүлсэн “Монгол Улсын хууль, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоолын 2024 оны хэрэгжилтийн тайлан”-д 11 Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр дүн шинжилгээ хийв.
- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг анх удаа Байнгын хороодоор хэлэлцүүлээ.

5.2.ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн талаар:



“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны хэрэгжилт, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийж, тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороодын 2025 оны 3 дугаар сарын 18, 25-ны өдрүүдийн хамтарсан хуралдаанаар, 2025.03.28, 31-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцлээ.

5.3.БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тайланд дүн шинжилгээ хийсэн талаар: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу дараах 9 тайланд дүн шинжилгээ хийв. Үүнд:



- Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланд;
- Төрийн албаны зөвлөлөөс хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх 2024 оны тайланд;
- Үндэсний статистикийн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланд;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланд;
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланд;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланд;
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланд;
- Төрийн албан хаагчийн Ёс зүйн хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланд;
- Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороодод хүргүүлсэн.

6.1.ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ

Төсвийн хяналтын чиглэлээр

Монгол Улсын Засгийн газраас 2025.04.30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-ийн төсөлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан талаар. Үүнд:



1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын тооцоолол, төсөөллийг хийж, 2024.03.15-ны өдрийн дотор санхүү, төсвийн болон эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн бөгөөд түүнд үндэслэн Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулсан байна.
2. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тооцоололтой харьцуулахад Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгагдсан эдийн засгийн бодит өсөлт, хэрэглээний үнийн өсөлтийн түвшин болон Засгийн газрын өрийн хэмжээ өндөр, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын дээд хэмжээ доогуур, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026-2028 онуудад алдагдалгүй байхаар тус тус төлөвлөсөн.
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.1-6.1.4-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.
4. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахад Засгийн газар олон нийтийн оролцоог ханган ажилласан байна. Төрийн бус байгууллага, хувийн хэвшил, төрийн байгууллагын төлөөллөөс нийт 54 задгай санал ирүүлсэн бөгөөд саналууд нь макро эдийн засгийн тогтвортой байдал, төсвийн сахилга бат, дотоодын үйлдвэрлэл, түүхий эдийн бодит төсөөлөл, орлого, татвар, өрийн бодлого, хөрөнгө оруулалт ба бүтээмж, төрийн зардлын бүтцийн шинэчлэл зэрэг чухал сэдвийг хамарч, эдгээр саналуудыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгаж, олон нийтийн оролцоог ханган ажилласан.
5. Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн төсөл нь Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн төлөвлөлтөд стратегийг хэрэгжүүлэх 4 зорилт, 8 арга хэмжээ, зорилт, арга хэмжээ бүрээр шалгуур үзүүлэлт гаргаж, төлөвлөсөн байна. Өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн төсөлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан эдийн засагт үр өгөөжтэй, тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг эхний ээлжид санхүүжүүлэх, аймаг, орон нутгийн үнэт цаасны үлдэгдэлд тодорхой шалгуур тавьж байгаа нь шинэ арга хэмжээнүүд байсан.

6.2.ТӨСВИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭХ ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТ



Төсвийн тодотголын төслийн хяналт:

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.25-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасны дагуу дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэв.

Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.



Төсвийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үе шатны хяналт:

2021.01.15-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2020.01.23-ны өдөр баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дагуу Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны дарга, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2026 оны төсвийн төслийн саналд шинжилгээ хийж, холбогдох танилцуулгыг бэлтгэв.



Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Зөвлөлийн дүрмээр хүлээсэн чиг үүрэг, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 7 удаагийн хуралдааныг зохион байгуулж дараах хууль, тогтоолын төсөлд хараат бус, бие даасан дүгнэлт, зөвлөмж гарган ажилласан.

